

Хайлуур жонш, түүний үйлдвэрлэл, хэрэглээ



1868 оны үеэс жоншийг дэлхий нийтээрээ “Fluorite” хэмээн нэрлэх болсон бөгөөд энэ нь Латин хэлний “Fluere” буюу “урсах” гэсэн үгнээс гаралтай. Тухайн үеэс жоншийг гоёл чимэглэл, гар урлал, засал чимэглэлд хэрэглэхээс гадна ган хайлуулахдаа шингэрүүлэгч болгон хэрэглэж байжээ.

Хайлуур жоншны найрлагын 51.1 хувийг кальци (Ca), 48.9 хувийг фтор (F) бүрдүүлдэг, метал бус эрдэс юм. 19-р зуунд ган хайлуулахад хайлуур жоншийг өргөн хэрэглэдэг байсан бол өнөө үед гангийн буюу төмрийн хайлш бэлтгэх, хөнгөн цагааны үйлдвэрлэл, гагнуурын электродын бүрхүүл, гангийн цутгуур, цементийн үйлдвэр, тусгай зориулалтын оптик шил үйлдвэрлэх, фторт устөрөгчийнхүчил болон бусад фторт нэгдлүүдийг гарган авахад ашиглаж байна. Өнөөгийн байдлаар дэлхийн хэмжээнд жилд 5.7-6.0 сая орчим тонн хайлуур жоншны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэрэглэж байна.

Дэлхийн хайлуур жоншны нөөц

Улс орнууд	Болит нөөц		Боломжит нөөц	
	Хэмжээ, мян.тн	Хувь, %	Хэмжээ, мян.тн	Хувь, %
Бразил	1000.0	0.4	3000.0	0.6
Хятад	21000.0	8.8	110.000	22.9
Мексик	32.000	13.3	40.000	8.3
Өмнөд Африк	41.000	17.1	80.000	16.7
Монгол	12.000	5.0	16.000	3.3
ОХУ	-	-	18.000	3.8
Испани	6.000	2.5	8.000	1.7
Франц	10.000	4.2	14.000	2.9
Кени	2.000	0.8	3.000	0.6
Намиби	3.000	1.3	5.000	1.0
Мороко	-	-	-	-
Бусад	112.000	46.7	183.000	38.1
Дүн	240.000	100.0	480.000	100.0

Монгол орны зүүн урд хэсгээс эхлэн Хэнтий аймгийг дайран хайлуур жоншны томоохон бассейн (илэрц) байдаг. 1954 онд нээгдсэн Бэрхийн уурхай нь манай орны хайлуур жоншны томоохон ордуудын нэг

Монгол улс жилд 300–460 мянган тоннхайлуур жоншны бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Манай орны жонш нь ОХУ, БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл болон бусад салбарт худалдаалагддаг. Өнгөрсөн жилүүдэд, ялангуяа 2011-2013 онд зах зээлийн нөхцөл ихээхэн таатай байсан тул олборлолт болон боловсруулах үйлдвэрүүд олноор ашиглалтад орж, жилдээ 400 орчим мян.тн-ыг олборлож байв. Гэвч ойрын ирээдүйд зах зээлийн нөхцөл сайжрахгүй төлөвтэй тул олборлолтын хэмжээ өсөх магадлал бага байна.

Монгол улсын жоншны үйлдвэрлэл

	нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Үйлдвэрлэлийн хэмжээ фф	мян.тн	50.8	98.8	57.2	61	51.6	80
Үйлдвэрлэлийн хэмжээ фк	мян.тн	200.2	278.1	82	117.6	55.8	100
Борлуулалтын орлого	тэрбум.төг	26.83	63.64	51.15	58.38	41.18	
Үнэ ФФ-97	доллар/тн	529.4	456.3	349.4	305.7	283.3	257
Үнэ ФК-85	доллар/тн	352.2	365.7	294	240	244.3	238

Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр 120-130 мянган тонн жоншны баяжмал буюу нийт экспортын бүтээгдэхүүний 30 хувийг үйлдвэрлэн худалдаалж буй ч, боловсруулаагүй эсвэл хэт доогуур боловсруулалттай бүтээгдэхүүний экспорт давамгайлж байна.

Эх сурвалж:

Б.Нямдаваа, С.Баяраа. МОНГОЛ ОРНЫ ХАЙЛУУР ЖОНШ ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРАХДАА ЯМАР ТЕХНОЛОГИОР БОЛОВСРОГДОН ГАРДАГ ТАЛААР. Proceedings of the Mongolian Academy of Sciences Vol. 52 No 2 (202) 2012

АМГТГ. 2017. МОНГОЛ УЛСЫН ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ӨНДӨР
ТЭГС, АМГТГ-ЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН,
2017-2020 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ, ХҮРЭХ ҮР ДҮН

Б.Төгс. Монголын жоншны салбарын орлого буурчээ. 2014.
<http://www.mongolianminingjournal.com/content/53681.shtml>